

АРЛИНГТОНЫ УЛСЫН СУРГУУЛЬ



“SECTION 504” ЖУРМЫН ГАРЫН АВЛАГА

2025 оны 7-р сар

**АРЛИНГТОНЫ УЛСЫН СУРГУУЛЬ
1973 ОНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ХУУЛИЙН 504-Р БҮЛЭГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАХИРГААНЫ УДИРДАМЖ, ЖУРАМ.**

Эдгээр заавар, журмын талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбогдоно уу:

Jennifer Lambdin
“Section 504” Хөтөлбөрийн Удирдагч
Arlington Public Schools
2110 Washington Blvd
Arlington, Va 22204
Tel. (703) 228-8838
Имэйл: jennifer.lambdin@apsva.us

Эсвэл

Dr. Darrell Sampson
“Section 504” Хөтөлбөрийн Хэрэгжилт Хянах Ажилтан
Сурагчийн Үйлчилгээний Газрын Гүйцэтгэх Захирал
Arlington Public Schools
2110 Washington Blvd
Arlington, Va 22204
Tel. (703) 228-6061
Имэйл: darrell.sampson@apsva.us

Арлингтон улсын сургууль (АУС) нь өөрийн хөтөлбөр, үйл ажиллагаанд элсэх, хамрагдах, эмчилгээ хийлгэхдээ яс үндэс, арьсны өнгө, гарал үүсэл, хүйс, хөгжлийн бэрхшээл, насаар нь ялгаварлан гадуурхдаггүй бөгөөд скаутууд болон хүүхэд залуучуудын бусад бүлгүүдэд тэгш эрх олгодог. Тэгш боломж, ялгаварлан гадуурхахгүй байх бодлогын талаар асуулт байгаа бол АУС-н “Section 504” Хөтөлбөрийн Зохицуулагч эсвэл Сурагчийн Үйлчилгээний Газрын Гүйцэтгэх Захиралтай холбоо барина уу.

**АРЛИНГТОНЫ УЛСЫН СУРГУУЛЬ
1973 ОНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ХУУЛИЙН 504-Р БҮЛЭГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАХИРГААНЫ УДИРДАМЖ, ЖУРАМ.**

АГУУЛГА

I.	Танилцуулга	1
II.	Ялгаварлан гадуурхахгүй байх тухай мэдэгдэл	1
III.	Section 504 Хөтөлбөрийн хүрээнд хамгаалагдах сурагчид	2
IV.	Child Find Хөтөлбөр.....	2
V.	Хөтөлбөрт санал болгох	3
VI.	Section 504 Хөтөлбөрийн Хороо.....	3
VII.	Үнэлгээ.....	4
VIII.	Хөтөлбөрт тэнцэх эсэхийг Тодорхойлох.....	5
IX.	Хөтөлбөрт хуваарилах	7
X.	Давтан үнэлгээ	9
XI.	Сахилгын журам	9
XII.	Процедурын хамгаалалт	12
XIII.	Арлингтоны Улсын Сургуулийн дотоод Section 504/Америкийн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн тухай Хуулийн Гомдол Шийдвэрлэх Журам	12
XIV.	Арлингтоны Улсын Сургуулийн Section 504 Хөтөлбөрийн Хараат бус Сонсголын Журам	14
	Section 504 Хөтөлбөрийн Хараат бус Сонсгол явуулах хүсэлт (Маягт)	17
	АУС-н Section 504 Хөтөлбөрийн Процедурын хамгаалалт (Тараах материал)	20

I. ТАНИЛЦУУЛГА

Энэхүү баримт бичиг нь 1973 оны Нөхөн Сэргээлтийн тухай Хуулийн 504-р Хэсэг ("Section 504") болон 1990 оны Америкийн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн тухай Хуулийн 2-р Зүйл ("Title II" эсвэл "ADA"¹)-ын холбогдох шаардлагуудыг тодруулсан болно.

504-р хэсэг нь АНУ-ын Боловсролын яамнаас Холбооны санхүүгийн тусламж авдаг хөтөлбөр, үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах зорилготой холбооны хууль юм. 504-р зүйлд “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Холбооны төсвийн хөрөнгөөр санхүүждэг аливаа хөтөлбөр, үйл ажиллагаанд шаардлага хангаж байгаа нөхцөлд зөвхөн хөгжлийн бэрхшээлийнх нь улмаас оролцуулахаас хасах, тэтгэмж олгохоос татгалзах, ялгаварлан гадуурхахыг хориглоно” гэж заасан байдаг. Хуулийн II Зүйлээр ялгаварлан гадуурхалтын эсрэг энэхүү заалт нь Холбооны төсвийн санхүүжилт авдаг эсэхээс үл хамааран муж болон орон нутгийн засгийн газрын бүх төрлийн үйлчилгээ, хөтөлбөр, үйл ажиллагаанд (улсын сургуулиудыг оролцуулан) мөн хамаарахаар заажээ.

“Section 504” журмын дагуу сургуулийн дүүрэг нь хөгжлийн бэрхшээлийн шинж чанар, хүнд байдлаас үл хамааран тухайн сургуулийн харьяалалд буй хөгжлийн бэрхшээлтэй, эрх үүссэн сурагч бүрт үнэ төлбөргүй зохист боловсрол² (FAPE) олгохыг шаарддаг. “Section 504”-д заасны дагуу FAPE нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн хувь боловсролын хэрэгцээг хөгжлийн бэрхшээлгүй сурагчидтай адил хэмжээнд хангахад чиглэсэн энгийн эсвэл тусгай боловсрол, холбогдох хөнгөлөлт, үйлчилгээнээс бүрдэнэ.

Сургуулийн дүүрэг нь “Section 504” хариуцсан Зохицуулагчтай байна. “Section 504” зохицуулагч нь “Section 504” ба “Title II” хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн сургуулийн дүүргийн үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй. Нэмэлт мэдээлэл авах эсвэл “Section 504” ба “Title II”-тай холбоотой асуулт байгаа бол “Section 504”-н Зохицуулагчтай холбогдоно уу. “Section 504”-н Зохицуулагчтай дараах хаяг, утасны дугаараар холбогдож болно.

Jennifer Lambdin
Section 504 Хөтөлбөрийн Удирдагч
Arlington Public Schools
2110 Washington Blvd
Arlington, VA 22204
Tel. (703) 228-8838
Имэйл: jennifer.lambdin@apsva.us

II. ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХГҮЙ БАЙХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Сургуулийн дүүрэг нь сурагч элсүүлэх, үйлчилгээ үзүүлэх, харилцах болон хөтөлбөр, үйл ажиллагаандаа сурагчдыг яс үндэс, арьс өнгө, үндэс угсаа, хүйс, хөгжлийн бэрхшээл, насаар нь ялгаварлан гадуурхахгүй гэдгээ сурагчид, эцэг эхчүүд, олон нийтэд тасралтгүй байнга мэдээлэхэд анхаарч байна.

Сургуулийн дүүргийн “Section 504”-н Зохицуулагч эсвэл АУС-н Сурагчид Үйлчлэх Албаны Захиралтай холбогдож, тус дүүргийн ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлогын талаар лавлана уу.

¹ Americans with Disabilities Act of 1990- 1990 оны Америкийн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Хууль. Цаашид “ADA” гэх.

² Free Appropriate Public Education- Төрөөс олгох үнэгүй, чанартай боловсрол. Цаашид FAPE гэх.

III. “SECTION 504” ЗААЛТААР ХАМГААЛАГДДАГ СУРАГЧИД

“Section 504”-н дагуу дараах нөхцөлд буй сурагчийг "хөгжлийн бэрхшээлтэй сурагч" гэж үзнэ:

1. амьдралын нэг буюу хэд хэдэн үндсэн үйл ажиллагааг ихээхэн хязгаарладаг бие махбодийн болон сэтгэцийн эмгэгтэй байх;
2. ийм хөгжлийн бэрхшээлтэй гэх бүртгэлтэй; эсвэл
3. ийм хөгжлийн бэрхшээлтөйд тооцдог.

Хэрэв аливаа хүн эдгээр гурван нөхцөлийн аль нэгд нийцэж байгаа бол “Section 504” (болон Title II)-н дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж тооцно. Гэвч “Section 504” нь зөвхөн нэг буюу хэд хэдэн амьдралын үйл ажиллагааг нь хязгаарлахуйц биеийн болон оюун санааны бэрхшээлтэй, сургуульд элсэх бусад шаардлага хангасан сурагчдад FAPE олгох шаардлагыг сургуулийн дүүргүүдэд тавьдаг.

Нөхцөл байдал нь хүний амьдралын нэн хэрэгцээт үйл ажиллагааг хязгаарлахуйц биш бол тухайн хүн “Section 504” -н дагуу үйлчилгээ авах эрхгүй. Тиймээс дээрх тодорхойлолтын зөвхөн хоёр дахь эсвэл гурав дахь нөхцөлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлсон сурагч нь ялгаварлан гадуурхалтаас хамгаалагдах боловч FAPE эсвэл “Section 504” Хөтөлбөрт заавал хамрагдах эрх **ҮҮСЭХГҮЙ**. Сурагч нь зөвхөн "бүртгэлтэй" эсвэл "хөгжлийн бэрхшээлтэй" гэж тооцогддог нь өөрөө FAPE-г заавал үзүүлэх “Section 504”-н хамгаалалтыг эхлүүлэхэд хангалтгүй юм.

Эрх үүсэхгүй хувь хүмүүс

Хууль бус мансууруулах бодис хэрэглэж байгаа, улмаар тухайн сургуулийн дүүрэг нь энэ зөрчлийн мөрөөр арга хэмжээ авч буй аливаа сурагчийг “Section 504”-н хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн тодорхойлолтод, мөн “Section 504”-н хамгаалалтад тус тус хамруулдаггүй. Хууль бус мансууруулах бодис хэрэглэхээ зогсоосон хүмүүсийг хамгаалалтаас хасах энэхүү зохицуулалтаас чөлөөлөх гурван нөхцөл байна:

1. Тухайн хүн нь мансууруулах бодисоос гаргах хяналттай хөтөлбөрийг амжилттай дүүргэж, мансууруулах бодис хэрэглэхгүй байгаа; эсвэл мансууруулах бодисоос бүрмөсөн гарч, мансууруулах бодис хэрэглэхээ больсон;
2. Тухайн хүн хараа хяналттай нөхөн сэргээх хөтөлбөрт хамрагдаж байгаа бөгөөд мансууруулах бодис хэрэглэхгүй байгаа; болон
3. Тухайн хүнийг мансууруулах бодис хэрэглэдэг гэж үндэслэлгүй тодорхойлсон боловч мансууруулах бодис хэрэглэдэггүй.

IV. Child Find Хөтөлбөр

АУС нь "child find" гэж нэрлэгддэг үйл ажиллагааг эрхлэн явуулдаг. Наад зах нь жил бүр АУС-с хөгжлийн бэрхшээлийн нөхцөл хангах сурагчдыг олж илрүүлэх, тодорхойлох, “Section 504” (болон Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Боловсролын тухай Хууль)-н хүрээнд сургуулийн дүүргийн хүлээх үүрэг хариуцлагын талаар олон нийтэд мэдээлэл өгөх үүрэг хүлээдэг. АУС нь сургуулийн дүүрэгт харьяалагддаг, нийтийн боловсролд хамрагддаггүй, нөхцөл шаардлагад нийцэх хөгжлийн бэрхшээлтэй сурагч бүрийг олж тогтоох, “Section 504” Хуулийн хүрээнд сургуулийн дүүргийн хүлээх үүрэг хариуцлагын талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон тэдний эцэг эх, асран хамгаалагчдад мэдээлэх талаар бүхий л хүчин чармайлтыг гаргаж байна.

V. (ҮЙЛЧИЛГЭЭНД) САНАЛ БОЛГОХ:

“Section 504” Хөтөлбөрт эрх хангах үнэлгээг тухайн сурагчийг хөгжлийн бэрхшээлтэй гэж үзсэн, улмаар “Section 504” -н үйлчилгээнд хамрагдах эрхтэй гэж үзсэн аливаа этгээдээс санал гаргаж болно. Санал гаргагчид эцэг эх, багш, зөвлөхүүд, туслах ажилтнууд, захиргааны ажилтан ажилчид болон сурагчийн талаар мэддэг бусад хүмүүс орно. Үнэлгээ явуулах саналыг аман болон бичгээр гаргаж болох бөгөөд тухайн сурагчийн сургууль дээрх Сурагчийг Дэмжих Зохицуулагч (SSC)-д өгөх ёстой. Санал гаргагч нь үнэлгээ явуулахаар хүсэлт гаргаж буй шалтгааныг тайлбарлах ёстой.

Саналыг хүлээн авмагц сургуулийн SSC үнэлгээ явуулах хүсэлтийг Сурагчийг Дэмжих Багт нэн даруй хүргүүлнэ. Сурагчийг Дэмжих Баг ажлын арав (10) өдрийн дотор хуралдаж саналыг хэлэлцэх бөгөөд шаардлагатай бол “Section 504” үнэлгээг гүйцэтгэхэд ямар мэдээлэл шаардлагатайг тодорхойлно. Уулзалтад сурагчийн эцэг эх, асран хамгаалагчийг оролцуулна.

Эсвэл Сурагчийг Дэмжих Багийн хурлын үеэр Сурагчийг Дэмжих Баг нь тухайн сурагчийг Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Боловсролын тухай Хууль³ (IDEA)-д хамаарах хөгжлийн бэрхшээлтэй гэж үзсэн тохиолдолд Сурагчийг Дэмжих Баг нь тухайн сурагчийг IDEA-н эрх тодорхойлох үнэлгээнд хамруулахаар санал гаргаж болно.

VI. SECTION 504 ХОРОО

“Section 504” Хороод нь тухайн сурагчийн тухай, үнэлгээний өгөгдлийн утга учир, эрх хангасан сурагчдад тохирох хөтөлбөрийн сонголтуудын талаар тодорхой мэдлэгтэй, олон талт мэргэшлийн хүмүүсээс бүрдсэн баг юм. Үнэлгээнд хамаарах мэдлэгтэй хүмүүст тухайлбал сурагчийн ерөнхий эрдмийн багш, үйлчилгээ үзүүлэгч (жишээ нь сургуулийн сувилагч эсвэл зөвлөх), сургуулийн захиргааны ажилтан, сурагчийн эцэг эх зэрэг хүмүүсийг ойлгоно. Сургуулийн дүүргийн “Section 504”-н зохицуулагчид мэдэгдэж, шаардлагатай бол тэдний тусламж шаардлагатай аливаа уулзалтад оролцоно.

“Section 504” Хорооны үүрэг нь “Section 504”-д санал болгосон хүсэлтийг хэлэлцэх, үнэлгээ, давтан үнэлгээ хийх, эрх хангах эсэхийг тодорхойлох, “Section 504” Төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай бол засварлах, “Section 504” илрэлийн тодорхойлолтыг хянах явдал юм.

Шийдвэр гаргахад “Section 504” Хороо нь:

1. Авьяас чадвар, сурлагын чадавхын шалгалт, багшийн зөвлөмж, биеийн байдал, нийгэм, соёлын байдал, дасан зохицох зан үйл зэрэг олон эх сурвалжаас авсан мэдээлэлд тулгуурлах; болон
2. Бүх эх сурвалжуудаас авсан мэдээллүүд нь баримттай, үнэн зөв эсэхийг шалгавал зохино.

Авагдаж буй мэдээллийн ач холбогдлыг тухайн сурагчийн хувь нөхцөл байдлаас хамаарч "Section 504" Хорооны гишүүд тодорхойлно.

³ Individuals with Disabilities Education Act - Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Боловсролын тухай Хууль. Цаашид IDEA гэж товчлох.

VII. ҮНЭЛГЭЭ

Сурагч нь "Section 504"-д заасан нөхцөл шалгуурт нийцэх хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлохдоо үнэлгээний үйл явцаас эхэлнэ. "Section 504" нь үл тохирох үнэлгээ сонгож, явуулах, улмаар үнэлгээний үр дүнг буруу хөрвүүлсний улмаас сурагчдыг буруу ангилалд оруулах, шаардлагагүйгээр хөгжлийн бэрхшээлтэй гэж ангилах, буруу хөтөлбөрт хуваарилах зэрэг явдлаас сэргийлэх үнэлгээний аргачлал ашиглахыг шаарддаг.

Сургуулийн дүүрэг нь сурагчийг хөгжлийн бэрхшээлтэй гэж ангилах юм уу эсвэл "Section 504" Төлөвлөгөөнд хамруулахаас өмнө сурагч бүрийг нэг бүрчлэн үнэлэх шаардлагатай. Ерөнхийдөө үнэлгээ гэдэг нь янз бүрийн эх сурвалжаас мэдээлэл цуглуулахыг хэлэх бөгөөд эдгээрт эрүүл мэндийн мэдээлэл, сэтгэл зүйн үнэлгээ, боловсролын үнэлгээ эсвэл сурагчийн боловсролын бүртгэл дэх бусад мэдээлэл, социологийн мэдээлэл, сурагчийн эцэг эх, асран хамгаалагчийн өгсөн мэдээлэл болон бусад холбогдох мэдээллийг ойлгоно.

Мэдээллийн төрөл, цар хүрээг тухайн сурагчид үнэлгээ хийхээр эмхлэн байгуулсан "Section 504" Хороо тодорхойлно. "Section 504" Хороо нь тухайн сурагчийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхээр бодитой шийдвэр гаргахад хангалттай мэдээлэл цугларсан эсэхийг нягтлах, хэрэв хангалтгүй гэж үзвэл ямар үнэлгээ болон/эсвэл нэмэлт мэдээлэл шаардлагатай буйг тодорхойлох шаардлагатай.

"Section 504" Хороо нь үнэлгээний явцад төрөл бүрийн эх сурвалжаас мэдээлэл авах ёстой бөгөөд энэ нь алдаа гарах магадлал хамгийн бага хэмжээнд байх боломжийг бүрдүүлэхэд чиглэдэг. Цугларсан мэдээллийг баримтжуулж, сурагчийн суралцах үйл явцтай холбоотой бүх чухал хүчин зүйлсийг харгалзан үзэх ёстой. Сурагчийн үнэлгээнд бусад эх сурвалжийн зэрэгцээгээр эмчийн эрүүл мэндийн оношийг харгалзан үзэж болох боловч "Section 504"-н үнэлгээгээр эмнэлгийн оношийг дангаар нь орлуулан ашиглахгүй, мөн эмнэлгийн онош байхгүй байгаа нь сурагчийг шалгуурт нийцэхгүй гэж дүгнэх шалтгаан болохгүй. Эмнэлгийн оношилгооны хамт авч үзэх бусад эх сурвалжид ур чадвар, сурлагын чадавхын тест, багшийн зөвлөмж, биеийн байдал, нийгэм, соёлын байдал, дасан зохицох зан үйл зэрэг орно. Хөгжлийн бэрхшээлтэй гэж үзсэн сурагчийг үнэлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй болон мөн энэ ангилалд хамаарч болох хүмүүсийн талаарх таамаглал, хэвшмэл ойлголтод найдах нь зохисгүй юм.

Сургуулийн дүүргийн шалгалт, үнэлгээнд ашиглаж буй материалууд нь:

1. тэдгээр нь ашиглах тодорхой зориулалтын дагуу туршигдаж баталгаажсан байх, мөн тухайн үнэлгээний материалыг боловсруулсан газраас гаргасан удирдамжийн дагуу бэлтгэгдсэн ажилтнууд үнэлгээг удирдаж байх;
2. зөвхөн оюуны тодорхой ганц түвшинг (IQ) хэмжих бус, боловсролын хэрэгцээтэй уялдсан тодорхой чиглэлүүдийг үнэлэхэд зориулсан тусгай сорилуудыг багтаасан байх;
3. Сурагчийн мэдрэхүй, хөдөлгөөний эсвэл ярих чадварын хязгаарлалтыг бус, харин эдгээр хязгаарлалтуудыг тухайлан шалгах шаардлагатайгаас бусад үед тухайн сурагчийн чадвар, мэдлэгийн түвшинг бодитоор үнэлэхэд чиглэсэн үнэлгээг ашиглах зэрэг шаардлагуудыг хангавал зохино.

"Section 504"-н дагуу хөгжлийн бэрхшээлтэй сурагч гэж үзэж буй сурагчид анх удаа үнэлгээ хийхийн өмнө эцэг эхийн бичгээр өгсөн зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай.

VIII. ЭРХ ХАНГАХ ЭСЭХ ШИЙДВЭР

Сурагч биеийн болон сэтгэцийн ямар нэгэн хязгаарлалттай бөгөөд энэ нь амьдралын чухал үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөөлж буй эсэхийг тогтоох шийдвэрийг хувь хүн бүрт нь үндэслэн гаргах ёстой. Энэхүү шийдвэрийг “Section 504”-н Хороо (сурагчийн талаарх ойлголттой, үнэлгээний мэдээлэл болон сургалтын хувилбаруудын талаар мэдлэгтэй хүмүүсийн бүлэг) гаргана. Сурагчийн эцэг эх, асран хамгаалагчийг хуралд оролцохыг урьж, Арлингтоны Улсын Сургууль (АУС) нь хурлыг эцэг эх юм уу асран хамгаалагчийн цагийн хуваарьт нийцүүлэх боломжит арга хэмжээг авна. “Section 504” Хороо шийдвэрээ гаргахдаа олон төрлийн эх сурвалжаас мэдээлэл авч, тэдгээрийг ашиглах ёстой. Хорооноос олж авсан, харгалзаж үзсэн мэдээллүүд, түүнчлэн эрх тодорхойлсон шийдвэрийг бичгээр гаргаж баримтжуулсан байх ёстой бөгөөд үнэлгээний үр дүн болон тэнцэх эсэх шийдвэрийн талаар эцэг эхчүүдэд бичгээр мэдэгдэх ёстой.

“Section 504” Хороо нь тухайн сурагч амьдралын нэг буюу хэд хэдэн чухал үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөөлөх биеийн эсвэл сэтгэцийн хязгаарлалттай эсэхэд үндэслэн эрх хангах эсэх шийдвэрийг гаргах ёстой.

Бие, сэтгэцийн эмгэг. Бие, сэтгэцийн эмгэгийг дараах байдлаар тодорхойлно.

- Дараах биеийн тогтолцооны аль нэг буюу хэд хэдэн үйл ажиллагаанд нөлөөлж буй физиологийн аливаа эмгэг, нөхцөл, гоо сайхны согог, анатомийн алдагдал, эдгээрт: мэдрэлийн; булчингийн тогтолцоо; тусгай мэдрэхүйн эрхтнүүд; амьсгалын зам, түүний дотор ярианы эрхтнүүд; зүрх судасны; нөхөн үржихүй, хоол боловсруулах, бэлэг эрхтэн-шээсний замын; цусны болон тунгалгийн тогтолцоо; арьс; ба дотоод шүүрэл; эсвэл
- аливаа сэтгэцийн болон сэтгэл зүйн эмгэг, тухайлбал оюуны хомсдол, органик тархины хам шинж, сэтгэл хөдлөлийн болон сэтгэцийн эмгэг, тодорхой суралцахуйн бэрхшээл.

Дээрх жагсаалт нь бие, сэтгэцийн эмгэгийг үүсгэж болзошгүй бүх өвчин, нөхцөл байдлын бүрэн жагсаалт хараахан биш юм.

Амьдралын гол үйл ажиллагаа. "Амьдралын гол үйл ажиллагаа" гэсэн нэр томъёонд дараахь үйл ажиллагаанууд багтана. Эдгээрт:

Өөрийгөө асрах	Хооллох
Гараар гүйцэтгэх ажил	Унтах
Алхах	Зогсох
Харах	Юм өргөх
Сонсох	Бөхийх
Ярих	Унших
Амьсгалах	Төвлөрөх
Суралцах	Сэтгэн бодох
Ажиллах	Харилцах

Эдгээрийн зэрэгцээ амьдралын гол үйл ажиллагаанд дархлааны тогтолцоо, эсийн хэвийн өсөлт, хоол боловсруулах, гэдэс, давсаг, мэдрэл, тархи, амьсгалын замын, цусны эргэлт, дотоод шүүрэл, нөхөн үржихүйн үйл ажиллагаа зэрэг "бие эрхтний гол үйл ажиллагаанууд" багтдаг.

Энэхүү амьдралын гол үйл ажиллагааны жагсаалт нь бүрэн жагсаалт биш юм.

Мэдэгдэхүйц хязгаарлалт Аливаа эмгэг сурагчийн амьдралын чухал үйл ажиллагаанд мэдэгдэхүйц хязгаарлалт учруулж буй эсэхийг тодорхойлохдоо сурагч тус бүрээр тусад нь үнэлгээ явуулж, “Section 504” Хороо шийдвэр гаргана.

“Мэдэгдэхүйц хязгаарлалт” гэх ойлголтыг өргөн хүрээнд ойлгох бөгөөд хэт хүнд зэргийн хязгаарлалт шаардах нь зохимжгүй байж болох ч тодорхой хэмжээний хязгаарлалт буйг нотлох өгөгдөлд суурилах шаардлагатай.

Ямар нэгэн хязгаарлалт нь амьдралын чухал үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөөлж байгаа эсэхийг тогтоохдоо хөнгөвчлөх арга хэмжээнүүдийн (mitigating measures) эерэг үр нөлөөг харгалзахгүйгээр үнэлэх ёстой. Хөнгөвчлөх арга хэмжээнд дараахь зүйлс орно.

- Эм
- Эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл
- Сул хараа дэмжих төхөөрөмжүүд (энгийн нүдний шил, контакт линзийг оруулахгүй)
- Протез
- Сонсголын аппарат, суулгац, төхөөрөмж
- Хөдөлгөөн дэмжих хэрэгслүүд
- Хүчил төрөгчийн аппарат, хэрэгслүүд
- Хөнгөвчлөх технологи
- Бусад хөнгөлөлт, зохицуулалт
- Сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулсан хэлмэрч, харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан уншигч зэрэг нэмэлт тусламж эсвэл үйлчилгээ;
- Зуршмал зан төлөвийн болон дасан зохицох мэдрэл дэмжих нэмэлт зохицуулалтууд

Иймд дээрх хөнгөвчлөх арга хэмжээний үр нөлөөг үндэслэн тухайн сурагч “мэдэгдэхүйц хязгаарлалттай” эсэх дүгнэлт гаргаж **болохгүй**.

Амьдралын зөвхөн нэг үндсэн үйл ажиллагааг ихээхэн хязгаарлаж буй согогыг хөгжлийн бэрхшээл тодорхойлоход харгалзаж үзэх бөгөөд энэ нь бусад үндсэн үйл ажиллагааг хязгаарлаж буй эсэхийг харгалзахгүй.

Хааяа илэрдэг (episodic) эсвэл түр намжсан (in remission) эмгэгүүд нь идэвхтэй үедээ амьдралын чухал үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөөлдөг бол хөгжлийн бэрхшээлд тооцогдоно. Энэ төрлийн эмгэгтэй сурагчид FAPE-н эрх үүснэ.

Түр чадвар алдах. Түр чадвар алдсан сурагч (жишээлбэл, тархи доргилт, түлэгдэлт, мөч хугарсан, богино хугацааны өвчин гэх мэт) “Section 504”-д түр хамрагдах боломжтой. Түр чадвар алдалт нь амьдралын нэг буюу хэд хэдэн үндсэн үйл ажиллагааг удаан хугацаагаар хязгаарлахад хүргэхээс бусад тохиолдолд үүнийг “Section 504”-д заасан хөгжлийн бэрхшээл гэж үзэхгүй. Түр чадвар алдалтыг шийдвэрлэхдээ чадвар алдалтын үргэлжлэх хугацаа (эсвэл таамаглаж буй эдгэрэх хугацаа), мөн тухайн чадвар алдалт нь амьдралын чухал үйл ажиллагаанд хэр хэмжээгээр нөлөөлж буй зэргийг харгалзан тохиолдол бүрээр нь тусад нь авч үзэх шаардлагатай.

IX. ХӨТӨЛБӨРТ ХУВААРИЛАХ

АУС нь сурагчийн хөгжлийн бэрхшээлийн шинж чанар, зэргээс үл хамааран сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй сурагч бүрт үнэ төлбөргүй зохист нийтийн боловсролыг (FAPE⁴) олгоно.

Сурагч “Section 504” -д заасан шаардлага хангасан гэж тогтоогдсоны дараа “Section 504” хороо нь сурагчид FAPE-г авахад шаардлагатай сургалтын хөтөлбөр, үйлчилгээ, тохирох хөнгөлөлтүүдийг тодорхойлно. Эдгээр үйлчилгээ, зохицуулалтыг “Section 504” Төлөвлөгөөнд бичгээр тусгана.

Зохист боловсролын үндэс нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн хэрэгцээнд нийцсэн ерөнхий болон тусгай боловсрол, холбогдох тусламж, үйлчилгээг хөгжлийн бэрхшээлгүй сурагчдын хэрэгцээг хангаж буй түвшинд үзүүлэх явдал юм. Зохист боловсрол нь ердийн сургалтын орчин дахь боловсрол, нэмэлт үйлчилгээ бүхий ердийн сургалтын орчин дахь боловсрол, тусгай хэрэгцээт боловсрол, холбогдох үйлчилгээнээс бүрдэж болно. Хөтөлбөрт хуваарилах шийдвэр нь тухайн сурагчийг хамгийн боломжит нээлттэй орчинд байхаар бодолцсон байх шаардлагатай.

“Section 504” Төлөвлөгөөнд зөвхөн тухайн сурагч FAPE-д хамрагдахад зайлшгүй шаардлагатай гэж үзсэн зохицуулалт, үйлчилгээг тусгах ёстой. Хороо нь сурагчийн хичээлийн хөтөлбөрт хөнгөлөлт оруулах, шалгалтын явцад хийх тохируулга, сахилга батын хөндлөнгөөс оролцож туслах стратеги эсвэл бусад тусгай үйлчилгээ, түүний дотор холбогдох үйлчилгээ зэргийг харгалзан үзэж болно. Сургалтын хөнгөлөлт зохицуулалтыг аль нэг төлөөллөөс санал болгож болох боловч Хороо нь сургуулийн орчинд хөнгөлөлт зохицуулалт шаардлагатай эсэх талаар шийдвэр гаргахдаа эдгээр хөнгөлөлтүүд нь тухайн сурагчийн хөгжлийн бэрхшээлтэй холбоотой эсэх, амьдралын үндсэн үйл ажиллагаанд нөлөөлж буй нөлөөлөл, улмаар тухайн хэрэгцээг нотлох тодорхой өгөгдөл зэрэгт тулгуурлах ёстой. Муж, дүүргийн түвшний шалгалтад ашиглах хөнгөлөлт зохицуулалтууд нь ангид тогтмол ашигладаг хөнгөлөлт зохицуулалтууд байх нь зүйтэй.

Хороо нь тухайн сурагчийг хөтөлбөрт шаардлага хангана гэж тогтоосны дараа нэн даруй “Section 504” Төлөвлөгөө боловсруулах буюу эсвэл энэ зорилгоор өөр уулзалт товлож болно. “Section 504” Төлөвлөгөөг боломжит хурдан хугацаанд, гол төлөв Хорооноос эрх хангах шийдвэр гарсанаас хойш хуанлийн 30 хоногийн хугацаанд боловсруулах нь зүйтэй. Сурагчийн эцэг эх, асран хамгаалагчийг “Section 504” Төлөвлөгөө боловсруулах бүх уулзалтанд оролцуулах бөгөөд, АУС зүгээс уулзалтуудыг тэдний цагийн хуваарьт нийцүүлэх бүх нөөц боломжийг ашиглана.

Сурагчийн “Section 504” Төлөвлөгөөнд ямар үйлчилгээ багтахыг тодорхойлохдоо хороо дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Эдгээрт:

1. Хамгийн Бага Хязгаарлалттай Орчин:

- a. Хороо нь тухайн “Section 504”-д хамрагдаж буй сурагчийг хөгжлийн бэрхшээлгүй сурагчидтай хамт суралцах боломжийг дээд зэргээр хангахуйцаар тооцож хөтөлбөр хуваарилалт хийх ёстой.

⁴ Free Appropriate Public Education- Төрөөс үзүүлэх үнэгүй зохист боловсрол. Цаашид FAPE гэх.

- b. Үйлчилгээ авч буй суралцагч нь нэмэлт тусламж, үйлчилгээтэй хослуулсан ердийн сургалтын орчинд хангалттай суралцах боломжгүй нь нотлогдсоноос бусад нөхцөлд сурагчид ердийн сургалтын орчин хамгийн тохиромжтой гэж Хороо үзнэ.
- c. Хэрэв Хороо үйлчилгээ авч буй сурагчийг ердийн сургалтын ангиас өөр хөтөлбөрт хуваарилах тохиолдолд тухайн хувилбар байршил нь сурагчийн гэрт ойролцоо байгаа эсэхийг харгалзаж үзвэл зохино.

2. Үнэ төлбөргүй Зохист Нийтийн Боловсрол

- a. “Section 504” Хороо “Section 504”-д хамрагдаж буй сурагчийн хувь хэрэгцээнд чиглэсэн үйлчилгээнүүд нь хөгжлийн бэрхшээлгүй сурагчидтай адил хангалттай түвшинд байгаа эсэхэд хяналт тавина.
- b. Эрх хангасан сурагчид “Section 504”-н дагуу олгож буй боловсролын хөтөлбөр нь эдгээр үйлчилгээг хаанаас, ямар этгээд үзүүлж буйгаас үл хамаарч үйлчилгээ авч буй сурагчийн эцэг эхэд үнэ төлбөргүй байна.
- c. Хэдийгээр сургуулийн дүүрэг нь “Section 504”-н шаардлагын дагуу үнэ төлбөргүй зохист нийтийн боловсрол санал болгосон ч эрх үүссэн сурагч болон/эсвэл түүний эцэг эх нь сурагчийг хувийн сургуульд суралцуулахаар сонгосон бол сургуулийн дүүрэг нь тухайн хувийн сургуулийн сургалтын төлбөрийг төлөх, эсвэл “Section 504” үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээхгүй.
- d. “Section 504”-н сурагчид нь хөгжлийн бэрхшээлгүй үе тэнгийнхэнд санал болгож буйтай адил сургуулиас гадуурх үйлчилгээ болон нэмэлт үйл ажиллагаанд хамрагдах боломжийг эдлэх эрхтэй.

“Section 504” Төлөвлөгөөний хувийг сурагчийн багш нарт, бусад үйлчилгээ үзүүлэгчдэд, мөн эцэг эхэд тус тус өгнө. Багш нар өөрсдийн хариуцаж буй сурагчдын “Section 504” төлөвлөгөөний заалтыг хэрэгжүүлэх ёстой.

504 Төлөвлөгөөг боловсруулсны дараа аль болох хурдан хэрэгжүүлж эхлэх бөгөөд шаардлагатай үед шинэчилнэ. Сурагчийн 504 Төлөвлөгөөг наад зах нь жилд нэг удаа хянаж үзнэ.

Сурагч Шилжүүлэх. Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй сурагч АНУ дотор нэг сургуулийн дүүргээс өөр сургуулийн дүүрэгт 504 Төлөвлөгөөтэй шилжиж ирсэн бол хүлээн авч буй сургуулийн дүүрэг төлөвлөгөө болон дагалдах бичиг баримтыг нэн даруй хянаж үзэх ёстой. Хэрэв “Section 504” хороо уг төлөвлөгөөг тохиромжтой гэж үзвэл тухайн сургуулийн дүүрэг төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэгтэй. Харин сургуулийн дүүрэг төлөвлөгөөг тохиромжгүй гэж үзвэл, сурагчийг дахин үнэлж, тухайн сурагчид тохирсон боловсролын хөтөлбөрийг тодорхойлох ёстой.

Сургалтын Орчин Сургуулийн дүүрэг нь үйлчилгээнд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн анги танхим, үзүүлж буй үйлчилгээ, үйл ажиллагаа нь сургуулийн дүүргийн бусад байгууламж, үйлчилгээ, үйл ажиллагаатай харьцуулж болохуйц түвшинд байх нөхцөлийг хангана.

Хичээлээс гадуурх үйлчилгээ. Бүх хичээлээс гадуурх болон нэмэлт үйлчилгээ, үйл ажиллагааг үйлчилгээнд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тэгш оролцоог хангасан байдлаар үзүүлэх ёстой. Эдгээр үйлчилгээ, үйл ажиллагаанд зөвлөгөө өгөх, биеийн тамирын болон чөлөөт цагийн үйл ажиллагаа, автобус, эрүүл мэндийн үйлчилгээ, клуб, биеийн тамирын хичээл, спорт, хөдөлмөр эрхлэлт зэрэг орно.

Х. ДАВТАН ҮНЭЛГЭЭ

Сургуулийн дүүрэг нь “Section 504”-н дагуу эрх үүссэн сурагчдыг тодорхой хугацаанд дахин үнэлэх ёстой. АУС нь “Section 504”-н дагуу эрх үүссэн сурагчдад гурван жил тутамд давтан үнэлгээ хийх бөгөөд, хэрвээ эцэг эх болон/эсвэл сургуулийн ажилтны зүгээс хүсэлт гаргавал үнэлгээг үүнээс эрт хийж болно.

“Section 504” Хороо нь сурагчийн эцэг эхэд мэдэгдэл илгээсний дараа хуралдаж, сурагчийн “Section 504”-н хүрээнд үүссэн эрх хэвээр байгааг тогтоохын тулд нэмэлт мэдээлэл шаардагдах эсэхийг шийднэ. Зарим тохиолдолд одоо байгаа өгөгдөл болон бусад мэдээллийг үүнд ашиглаж болно. Хороо шинээр үнэлгээ хийх шаардлагатай гэж үзвэл эдгээр үнэлгээг зөвшөөрсөн эцэг эхийн зөвшөөрлийг авах шаардлагатай.

“Section 504”-д мөн сургуулийн дүүрэг нь сурагчийн боловсролын хөтөлбөрт томоохон өөрчлөлт оруулахаас өмнө дахин үнэлгээ хийхийг шаарддаг. Удаан хугацаагаар (нэг удаад 10-аас дээш хичээлийн өдөр) хичээлээс түдгэлзүүлэх нь боловсролын хөтөлбөрт томоохон өөрчлөлт гэж тооцогддог. Түүнчлэн нэг хичээлийн жилд богино хугацаагаар хичээлээс түдгэлзүүлсэн нийлбэр нь 10 хоногоос хэтэрсэн бөгөөд энэ нь давтагдсан шинжтэй бол мөн боловсролын хөтөлбөрт томоохон өөрчлөлт гэж үзнэ. Мөн сурагчийг нэг төрлийн хөтөлбөрөөс нөгөөд шилжүүлэх, эсвэл холбогдох үйлчилгээг зогсоох, эсвэл мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулах нь боловсролын хөтөлбөрт томоохон өөрчлөлт гэж тооцогдож, дахин үнэлгээ хийх шаардлагатай болно.

“Section 504” Үйлчилгээг Дүүсгавар Болгох

Эрх үүссэн сурагчийн багш, эцэг эх, сурагч өөрөө, эсвэл сургуулийн захирал нь “Section 504” Хороонд дахин үнэлгээ хийх хүсэлт гаргаж, тухайн сурагч “Section 504” үйлчилгээнд цаашид хамрагдах эрхтэй эсэхийг тогтоолгох боломжтой. Ийм хүсэлтийг хянахдаа “Section 504” Хороо дараах алхмуудыг гүйцэтгэнэ:

1. тухайн үед хүчинтэй бүх үнэлгээ болон бусад холбогдох мэдээллийг авч үзэх;
2. шинэ, албан ёсны үнэлгээ хийх шаардлагатай эсэхийг тодорхойлох; болон
3. сурагчийг “Section 504”-н дагуу эрх үүсэх сурагч мөн эсэхийг шийднэ. Үүний хүрээнд “Section 504” Хороо дараах зүйлсийг баталгаажуулах ёстой:
 - a. Сурагчийн эцэг эх хорооны хурлын талаар мэдэгдэл авсан байх;
 - b. шийдвэрээ бичгээр баримтжуулах; болон
 - c. Эцэг эхэд хорооны шийдвэрийн талаарх бичгээр мэдэгдэх болон “Section 504”-н Процедурын Хамгаалалт (Procedural Safeguards)-ын хувийг өгсөн байх.

XI. САХИЛГЫН АРГА ХЭМЖЭЭ

“Section 504” нь үйлчилгээ авах эрх үүссэн хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын сахилга батын асуудалд хамаарах тусгай хамгаалалтыг олгодог. 10 хоногоос дээш хугацаагаар удаан хугацаагаар хөтөлбөрөөс хасах, мөн богино хугацаагаар хөтөлбөрөөс хасах байдал давтагдаж, эдгээрийн нийлбэр хугацаа 10-аас дээш хоног хуримтлагдсан нөхцөлд тусгай журмаар зохицуулна. “Section 504” хуулинд үйлчилгээ авах эрх үүссэн хөгжлийн бэрхшээлтэй сурагчийг тухайн сурагчийн хөгжлийн бэрхшээлийн онцлогоос үүдэлтэй сахилга батын зөрчлийн улмаас сургуулиас 10-аас дээш хоногоор хасах, сургуулиас түдгэлзүүлэхгүй гэж заасан. Мөн “Section 504” нь сургуулийн дүүргийг үйлчилгээ авах эрх үүссэн хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг хөгжлийн бэрхшээлгүй сурагчдаас илүү хүнд шийтгэл хүлээлгэхийг хориглодог.

Сахилгын журам:

“Section 504” үйлчилгээ авч буй эрх бүхий сурагчид сахилгын асуудалд холбогдсон тохиолдолд дараах журмыг баримтална.

1. Хичээлийн 10 хоног буюу түүнээс бага хугацаанд (“богино хугацаагаар хасах”) хичээлээс түдгэлзүүлэх шийтгэл нь боловсролын хөтөлбөрт томоохон өөрчлөлтөд тооцогдохгүй тул Хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй Нөлөөлөл Тодорхойлох Үнэлгээ (“MDR”) явуулахыг шаардахгүй.
2. Олон удаагийн дараалсан богино хугацааны түдгэлзүүлэлт 10 хичээлийн өдрөөс хэтэрсэн бол энэ нь боловсролын хөтөлбөрт томоохон өөрчлөлтөд тооцогдох бөгөөд Хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй Нөлөөлөл Тодорхойлох Үнэлгээ (“MDR”) явуулах шаардлагатай. Богино хугацааны түдгэлзүүлэлт давтагдах шинжтэй байгааг тодорхойлохын тулд дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ:
 - a. түдгэлзүүлэлт тус бүрийн үргэлжлэх хугацаа;
 - b. сурагчийг сургуулиас түдгэлзүүлсэн нийт хугацаа;
 - c. түдгэлзүүлэлтүүд хоорондын зай; болон
 - d. сурагчийн одоогийн сахилга бат нь өмнөх удаа дараалан түдгэлзүүлэхэд хүргэсэн үйл явдлуудтай адил төстэй байгаа эсэх зэрэг болно.
3. Нэг удаад 10-аас дээш хичээлийн хоногоор сахилгын шийтгэл ногдуулах нь (“удаан хугацаагаар түдгэлзүүлэх”) нь боловсролын хөтөлбөрт томоохон өөрчлөлтөд тооцогддог тул MDR шаардлагатай.
4. Дээрхтэй хамаарахгүй хүчин зүйлс
 - a. Мансууруулах бодис, согтууруулах ундаа хууль бусаар хэрэглэсэн, үйлчилгээнд хамрагдаж буй сурагчийг хар тамхи, согтууруулах ундаа хэрэглэсэн зөрчлийнх нь улмаас сургуулиас түдгэлзүүлж болох бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлгүй сурагчдад ногдуулдаг сахилгын шийтгэлтэй адил байна.
 - b. Энэ нөхцөлд “Section 504”-н үнэлгээ юм уу, MDR эсвэл хараат бус сонсгол явуулах боломжийг сурагчид олгохгүй бөгөөд шаардлагагүй юм. Боловсролын үйлчилгээг ийм зөрчлийн улмаас сахилгын шийтгэл ногдуулсан хөгжлийн бэрхшээлгүй сурагчдад үзүүлдэг түвшинтэй адил байна.

“Section 504” Төлөвлгөөнд хамрагдаж буй сурагчийг удаан хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэрийг хэлэлцэж байх үед, эсвэл богино хугацаагаар түдгэлзүүлж байсан бөгөөд энэ байдал нь давтагдах шинжтэй тохиолдол “Section 504” Хороо (Сурагчийн тухай ойлголтой, үнэлгээний өгөгдөл, хөтөлбөр хуваарилалтын талаар мэдлэгтэй бүлэг) хуралдаж, сурагчийн сахилгын зөрчил болон хөгжлийн бэрхшээлийн хамаарлыг MDR-р тодруулж, сахилгын зөрчил нь сурагчийн хөгжлийн бэрхшээлийн онцлогоос үүдэлтэй эсэхийг тодорхойлно. Сурагчийн эцэг эх, асран хамгаалагчийг MDR-д урьж оролцуулна. Хорооны гишүүд ийм шийдвэр гаргахдаа төрөл бүрийн эх сурвалжаас авсан, сурагчийн хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт өгөхүйц шинэ мэдээлэлтэй байх ёстой бөгөөд эдгээрт ирц, сурлагын бүртгэл, сэтгэл зүйн үнэлгээний мэдээлэл, сахилга батын төлөвлөлт, сахилгын бүртгэл, ажилтны ажиглалт, эцэг эхийн мэдээлэл, тайлбар тэмдэглэл гэх мэт багтана.

“Section 504” Хороо сурагчийн зан авир нь сурагчийн хөгжлийн бэрхшээлийн илрэл байсан эсэхийг тогтооно. Дараах тохиолдолд зан авирыг сурагчийн хөгжлийн бэрхшээлийн илрэл гэж үзнэ:

1. Сахилга батын зөрчил нь сурагчийн хөгжлийн бэрхшээлээс үүдсэн, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй шууд хамааралтай; **эсвэл**
2. Энэхүү зөрчил нь сургуулийн зүгээс сурагчийн “Section 504” төлөвлөгөөг хэрэгжүүлж чадаагүйгээс шууд шалтгаалсан.

Хорооны шийдвэрийг бичгээр баримтжуулан, сурагчийн эцэг эхэд “Section 504” Процедурын Хамгаалалт баримтын хуулбартай хамт өгнө.

Хэрэв Хороо сахилга батын зөрчил нь хөгжлийн бэрхшээлээс үүдээгүй гэж дүгнэсэн бол сургууль нь адил төрлийн зөрчил гаргасан хөгжлийн бэрхшээлгүй сурагчдыг шийтгэдэгтэй адил жишгээр сургуулиас түдгэлзүүлэх шийтгэлийг оногдуулж болно. Түдгэлзүүлэх хугацаанд сургууль нь “Section 504” -д хамрагдаж буй сурагчид боловсролын үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээхгүй бөгөөд энэ нь адил шийтгэл хүлээсэн хөгжлийн бэрхшээлгүй сурагчдад үзүүлдэггүй үйлчилгээтэй адил байна.

Хэрэв сахилга батын зөрчил нь хөгжлийн бэрхшээлээс үүдсэн гэж тогтоосон бол сурагчийг сургуулиас түдгэлзүүлэхгүй бөгөөд Хороо тухайн сурагчийн “Section 504” төлөвлөгөөг дахин хянаж, одоогийн сургалтын хөтөлбөр нь тохиромжтой эсэхийг үнэлж, шаардлагатай бол шинэчилнэ.

Сургууль дотор түдгэлзүүлэх (“In-School Suspensions” буюу ISS): Хичээлийн 10 хоногоос дээш хугацаатай (дараалсан эсвэл хуримтлагдсан) сургууль доторх түдгэлзүүлэлт (“ISS”) нь боловсролын хөтөлбөрт томоохон өөрчлөлт байж болох тул ISS нь сурагчийн боловсролын хөтөлбөр, үйлчилгээ тасалдуулахад хүргэвэл MDR шаардлагатай болно.

Автобусны үйлчилгээг түдгэлзүүлэх: Сургуулийн автобусны үйлчилгээг түдгэлзүүлэх нь боловсролын хөтөлбөрт томоохон өөрчлөлтөд тооцогдож болно. Сургуулийн дүүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй сурагч өөртөө болон бусдад аюул учруулж байгаа тохиолдолд түүнд автобусны үйлчилгээ үзүүлэх хэлбэр, аргыг өөрчилж болно. Автобусанд гаргасан сахилгын зөрчлийг сургууль дээр гарсан сахилгын зөрчилтэй адил зарчмаар шийдвэрлэнэ.

ХИИ. ПРОЦЕДУРЫН ХАМГААЛАЛТ

Сургуулийн дүүрэг нь сурагчийг тодорхойлох, үнэлэх, хөтөлбөрт хуваарилахтай холбогдох процедурын хамгаалалтын тогтолцоог ашиглаж байна. Энэхүү систем нь дараахаас бүрдэнэ:

1. Мэдэгдэл;
2. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн эцэг эх, асран хамгаалагчид боловсролын бүх бүртгэлийг шалгаж, хянах боломж;
3. Сурагчийн эцэг эх, асран хамгаалагчийг оролцуулах, өмгөөлөгчийн төлөөллийн оролцоог хангасан хараат бус сонсгол; болон
4. Хараат бус сонсголын шийдвэрийг давж заалдах хяналтын журам.

АУС-н “Section 504”-н Процедурын Хамгаалалт баримтын хуулбарыг энэ гарын авлагын төгсгөлд, таны суралцагчийн сургуулиас, АУС-н Эцэг Эхийн Мэдээллийн төвөөс эсвэл АУС-н www.apsva.us вэбсайтаас авч болно.

ХИИ. АРЛИНГТОНЫ УЛСЫН СУРГУУЛИЙН ДОТООД “SECTION 504”/АМЕРИКИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХУУЛЬ ГОМДОЛ ГАРГАХ ЖУРАМ.

Сургуулийн дүүрэг нь иргэдийг хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхсан, улмаар “Section 504” юм уу “”ADA хуулийн II Зүйлийг (Title II)-г зөрчсөн гэж үзсэн нөхцөлд сургуулийн дүүргийн “Section 504” -н Зохицуулагчд бичгээр гомдол гаргаж болно. Гомдлыг бичгээр хүлээн авсны дараа сургуулийн хэлтэс нь бичгээр гаргасан гомдолд тусгагдсан үндэслэлүүдийг шалгаж, шуурхай, шударгаар шийдвэрлэхийн тулд хүчин чармайлт гаргах ёстой.

1. “Section 504/ II Зүйл Үндэслэлээр Гомдол Гаргах

Гомдлыг сурагч, сурагчийн эцэг эх, эцэг эх эсвэл сургуулийн дүүргийн ажилтан гаргаж болно. Гомдол нь дараахь шаардлагыг хангасан байх ёстой:

- Гомдол бичгээр байх ёстой.
- Гомдолд наад зах нь дараахь зүйлсийг агуулсан байх ёстой. Эдгээрт:
 - (1) гомдлын үндэслэл;
 - (2) гомдлын үндэслэл болсон баримтууд, түүний дотор бүх гэрчийн жагсаалт;
 - (3) Гомдлын мөрөөр авбал зохих шаардаж буй шийдэл; болон
 - (4) гомдол гаргагчийн гарын үсэг, гомдол гаргасан огноо зэрэг болно.

Бичгээр гаргасан гомдлыг сургуулийн дүүргийн “Section 504” -н Зохицуулагчд дараах хаягаар ирүүлнэ.

Jennifer Lambdin
“Section 504” Зохицуулагч
Arlington Public Schools
2110 Washington Blvd
Arlington, VA 22204
Tel. (703) 228-8838
Имэйл: jennifer.lambdin@apsva.us

Гомдлын талаар аль болох шуурхай, үндэслэл бүрдсэнээс хойш хичээлийн гучин (30) хоногийн дотор мэдэгдэх ёстой. Аливаа онцгой нөхцөл байдлын улмаас “Section 504”-н Зохицуулагч энэ хугацааг өөрөө шийдэн сунгаж болно.

Гомдол гаргагч нь амаар болон бичгээр нотлох баримт гаргаж, гэрчийг тогтоох боломжтой.

2. Мөрдөн байцаалт болон бичгээр Тайлан үйлдэх

“Section 504” Зохицуулагч эсвэл тэдний үүрэг гүйцэтгэгч нь сургуулийн дүүрэг нь “Section 504” болон “ADA” хуулийг сахиж байгаа эсэхийг тодорхойлохын тулд гомдлыг бие даан шалгана. “Section 504” Зохицуулагч эсвэл түүний үүрэг гүйцэтгэгч гомдлыг хүлээн авснаас хойш дөчин тав (45) хичээлийн өдрийн дотор гомдол гаргагчид мөрдөн байцаалтын талаар бичгээр тайлан (“Тайлан”) гаргаж өгнө. Тайлан нь дараахь мэдээллийг агуулсан байна. Эдгээрт:

- Гомдол гаргагчийн гаргасан үндэслэл болон гомдлын мөрөөр авах арга хэмжээний тухай мэдэгдэл;
- Тал тус бүрийн гаргаж буй үндэслэл баримтын тайлбар;
- Гомдлыг шийдвэрлэх оролдлогыг тодорхойлсон тайлбар;
- Ярилцсан гэрчүүдийн жагсаалт, мөрдөн байцаалтын явцад хянаж үзсэн баримтууд;
- Баримт тус бүрийг нотлох баримтын дагуу зохицуулагч эсвэл түүний төлөөлөгчийн тодорхойлсон нотлох баримтуудын тайлбар мэдэгдэл;
- “Section 504” Зохицуулагч эсвэл түүнийг төлөөлөх этгээдийн зүгээс тухайн гомдлын үндэслэлтэй эсэхийг хөдөлшгүй нотолгоон дээр үндэслэн гаргасан дүгнэлт; болон
- Хэрэв “Section 504” Зохицуулагч эсвэл түүнийг төлөөлөх этгээд уг гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл “Section 504” Зохицуулагч эсвэл түүнийг төлөөлөх этгээдийн гаргасан гомдлыг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээг тайланд тусгана.

Шаардлагатай гэж үзвэл хугацааг хичээлийн дөчин таван (45) хоногоор сунгаж болох бөгөөд үүнийг “Section 504” Зохицуулагч эсвэл түүнийг төлөөлөх этгээд шийднэ. Хугацаа сунгасан тухай гомдол гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

3. Давж заалдах боломж

Гомдол гаргагч нь “Section 504” Зохицуулагч эсвэл түүнийг төлөөлөх этгээдийн дүгнэлт тайланг хүлээн авснаас хойш хичээлийн арав (10) хоногийн дотор сургуулийн дүүргийн ерөнхий захирал эсвэл түүнийг орлох албан тушаалтанд бичгээр шийдвэрийг давж заалдах боломжтой. Давж заалдах хүсэлтийг хүлээн авсны дараа сургуулийн дүүргийн ерөнхий захирал эсвэл түүнийг орлох албан тушаалтан гомдол гаргагчийн давж заалдсан хүсэлт болон Дүгнэлт тайлангийн хамт хянан үзэж, хичээлийн гучин (30) хоногийн дотор гомдол гаргагчид бичгээр хариу өгнө. Сургуулийн дүүргийн ерөнхий захирал эсвэл түүнийг орлох албан тушаалтан нь “Section 504” Зохицуулагч эсвэл түүнийг төлөөлөх этгээдийн Дүгнэлт тайланд гаргасан шийдвэрийг нэг бол хэвээр батлах эсвэл цуцлах шийдвэрийн аль нэгийг гаргана.

Шаардлагатай гэж үзвэл хугацааг гучин (30) хичээлийн хоногоор сунгаж болох бөгөөд үүнийг сургуулийн дүүргийн ерөнхий захирал эсвэл түүнийг орлох албан тушаалтан шийднэ. Хугацаа сунгасан тухай гомдол гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

4. Гомдол гаргагчийн хамгаалалт

Сургуулийн дүүрэг юм уу эсвэл ажилтнуудын зүгээс гомдол гаргасан, эсвэл гомдол гаргаж хэлэлцүүлэх үйл явцад оролцсон хүнийг дарамтлах, албадах, айлган сүрдүүлэх, эсвэл ялгаварлан гадуурхахыг хориглоно.

Гомдол гаргаж хэлэлцүүлэх журмын талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл сургуулийн дүүргийн “Section 504” Зохицуулагчтай холбогдоно уу.

XIV. АРЛИНГТОНЫ УЛСЫН СУРГУУЛИЙН “SECTION 504” ХАРААТ БУС СОНСГОЛЫН ЖУРАМ

Хараат бус сонсгол гэдэг нь “Section 504”-н дагуу сурагчийг тодорхойлох, үнэлэх, боловсролын хөтөлбөрт хуваарилахтай холбоотой эцэг эх(чүүд) болон сургуулийн дүүргийн хооронд үүссэн санал зөрөлдөөнийг зохицуулахад чиглэсэн хөндлөнгийн сонсголын ажилтны хэрэгжүүлдэг захиргааны үйл ажиллагаа юм.

“Section 504” Хараат Бус Сонсголын Журам

1. “Section 504”-н дагуу хөгжлийн бэрхшээлтэй сурагчийг илрүүлж тогтоох, үнэлгээ хийх, эсвэл боловсролын хөтөлбөрт хуваарилахтай холбоотойгоор эцэг эх болон сургуулийн дүүргийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх зорилгоор хараат бус сонсгол явуулах боломжтой. 34 C.F.R. § 104.36.-г үзнэ үү.

- (a) Мансуурах эсвэл согтууруулах ундаа хэрэглэж буй сурагчид хамаарах онцгой тохиолдол. Сургуулийн дүүрэг нь “хууль бус хар тамхи хэрэглэж байгаа эсвэл согтууруулах ундаа хэрэглэж байгаа” хөгжлийн бэрхшээлтэй аливаа сурагчид хариуцлага тооцохдоо хөгжлийн бэрхшээлгүй сурагчдад хариуцлага тооцдогтой адил түвшинд сахилгын арга хэмжээ авч болно. 29 U.S.C. § 705(20)(C)(iv). Түүнчлэн сурагчийн хууль бусаар хар тамхи эсвэл согтууруулах ундаа идэвхтэй хэрэглэж буйтай холбогдох сахилгын асуудлуудыг сонсголоор авч хэлэлцэх боломжгүй. *Id-г харна уу.*

2. Сонсгол явуулах хүсэлт гаргах

- (b) Сонсгол явуулах өргөдлийг бичгээр гаргаж дараах хаягаар сургуулийн дүүргийн “Section 504” Хяналтын Албан Тушаалтан, Сурагчийн Үйлчилгээний Гүйцэтгэх Захиралд (Хяналтын Албан Тушаалтан) илгээнэ:

Dr. Darrell Sampson
Section 504 Compliance Officer, Executive Director, Office of Student Services
Arlington Public Schools
2110 Washington Blvd
Arlington, Va 22204
Tel. (703) 228-6061
Имэйл: darrell.sampson@apsva.us

- (c) Сонсгол явуулахад хүргэсэн маргаан гарснаас хойш хуанлийн ерэн (90) хоногийн дотор сонсгол явуулах хүсэлт гаргах ёстой. Сонсголын хүсэлт нь дараахь мэдээллийг агуулсан байх ёстой.
- (i) Сурагчийн нэр, сурагчийн оршин суугаа газрын хаяг (эсвэл орон гэргүй сурагчийн хувьд холбоо барих мэдээлэл), суралцаж буй сургуулийн нэр;
 - (ii) Орон гэргүй сурагч эсвэл залуучуудын тухайд (725(2) of the McKinney-Vento Homeless Assistance Act (42 U.S.C. § 11434a(2)-т хамаарах заалтын дагуу) тухайн сурагчтай холбоо барих боломжтой мэдээлэл болон суралцаж буй сургуулийн нэр;
 - (iii) Гомдол гаргагчийн санал нийлэхгүй байгаа, сургуулийн дүүргээс гаргасан шийдвэр(үүд)-ийн тодорхойлолт, үүнд ийм шийдвэртэй холбоотой баримтууд; болон
 - (iv) Тухайн талд ирүүлсэн, гомдол гаргах үед мэдэгдэж байгаа тухайн асуудлыг шийдвэрлэх тухай санал.

3. Сонсгол Хариуцсан Албан Хаагчийг томилох

- (a) Хяналтын ажилтан нь сонсгол явуулах хүсэлтийг хүлээн авсны дараа хараат бус сонсголын ажилтныг томилно.

4. Сонсголын өмнөх журам

- (a) Сонсголын ажилтан нь сонсгол болохоос өмнө дараахь асуудлыг хариуцна:
- (i) Томилогдсоноос хойш ажлын тав (5) хоногийн дотор хоёр талд тохирсон шүүх хуралдааны огноо, цаг, байршлыг баталгаажуулж, шүүх хуралдаан болох өдөр, цаг, байршлыг хоёр талд бичгээр мэдэгдэх.
 - (ii) Сонсголоор шийдвэрлэвэл зохих асуудлыг тодорхойлох.
 - (iii) Сонсголд талууд өмгөөлөгчөөр төлөөлүүлэн оролцох эсэхийг тодруулах.
 - (iv) Сонсголыг бичлэгийн төхөөрөмж эсвэл шүүхийн сурвалжлагчийн аль нэгээр үнэн зөв бүртгэлжүүлж байгаа эсэхийг баталгаажуулах.
- (b) Шүүх хуралдаанд оролцох гэрчүүдийн жагсаалт, нотлох баримт бичгүүдийг (тал тус бүрийн шүүх хуралдаанд ашиглахаар төлөвлөж буй бүх үнэлгээ, холбогдох зөвлөмж зэргийг багтаана) талууд харилцан солилцох ба сонсгол болохоос ажлын тав (5)-аас доошгүй хоногийн өмнө сонсголын ажилтанд хүлээлгэн өгсөн байх ёстой. Сонсголын ажилтан нь сонсгол болохоос ажлын таваас доошгүй хоногийн өмнө ирүүлээгүй нотлох баримтуудыг болон гэрчийн мэдүүлгийг сонсголд оруулахгүй байх эрхтэй.
- (c) Шаардлагатай бол сонсголын өмнөх хурлыг зохион байгуулах хэрэгтэй.

5. Сонсголын журам

- (a) Талууд сонсголд дараахь эрхтэй:
 - (i) Сонсголд оролцох болон өөрийн зардлаар өмгөөлөгчөөр төлөөлүүлэх;
 - (ii) нотлох баримт гаргаж, гэрчээс байцаалт авах; болон
 - (iii) сонсголын тэмдэглэлийн хуулбар эсвэл бичлэгийн хуулбарыг авах (холбогдох зардлыг хүсэлт гаргасан тал хариуцах).
- (b) Сурагчийн нэрийн өмнөөс хүсэлт гаргасан сонсголын хувьд тухайн сурагч сонсголд оролцож болно.
- (c) Сонсголтой холбогдуулан сонсгол хариуцсан ажилтан дараах үүргийг гүйцэтгэнэ:
 - (i) Шударга, хараат бус байдлыг хангах уур амьсгал бүрдүүлэх.
 - (ii) IDEA-ийн дагуу мужаас баталсан журмын дагуу шаардлагатай үед сургуулийн дүүргээс эцэг эхийн үүрэг гүйцэтгэгч төлөөллийг томилох боломжоор хангах.
 - (iii) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүртгэлийг үнэн зөв хөтлөх.
 - (iv) Сонсголд ирүүлсэн нотлох баримтад үндэслэн баримтын болон хуулийн дүгнэлтийг бүх талуудад бичгээр гаргаж өгөх.
 - (v) Сонсголд оролцогч талуудын аль нэгнийх нь хүсэлтээр сонсголыг үргэлжлүүлээгүй нөхцөлд томилогдсон өдрөөс хойш хуанлийн ерэн (90) хоногийн дотор бичгээр шийдвэр гаргана. Хүндэтгэн үзэх шалтгаантай бол сонсголын ажилтан сонсголыг үргэлжлүүлэх боломжтой.
 - (vi) Нэхэмжлэл гаргагч талд баримтаар нотлох үүргийг даалгах.
- (d) Сонсголын ажилтан нь шийдвэр гарснаас хойш хуанлийн гуч (30) хоногийн хугацаанд бүх бүртгэлийг хадгална. Давж заалдах хүсэлт гарсан тохиолдолд Хэрэгжилт Хянах ажилтан сонсголын ажилтанд хянан байцаагч ажилтны нэр, хаягийг өгч, бүртгэлийг хянан байцаагч руу шилжүүлэх үүрэг өгнө. Сонсголын ажилтан нь Хэрэгжилт Хянах ажилтны хүсэлт гаргаснаас хойш ажлын гурав (3) өдрийн дотор бүртгэлийг хянан байцаагч руу шилжүүлнэ. Давж заалдах гомдол гаргаагүй тохиолдолд сонсголын ажилтан нь бүртгэлийг Хэрэгжилт Хянах ажилтанд хүргүүлнэ.

Хянах журам: Хянан байцаагч нь хараат бус сонсголын шийдвэрийг давж заалдах үед хяналт явуулах боломжтой.

“Section 504” Хянах журам

1. Сонсголын ажилтны шийдвэртэй санал нийлээгүй аль ч тал уг шийдвэрийг хяналтын байцаагчид давж заалдаж болно. 34 CFR § 104.36-г үзнэ үү.
2. Давж заалдах гомдол гаргасан тал сонсголын ажилтны шийдвэр гарсан өдрөөс хойш хуанлийн гучин (30) хоногийн дотор сургуулийн дүүргийн Хяналтын Албан Тушаалтанд бичгээр давж заалдах мэдэгдэл гаргаж бүртгүүлж болно.
3. Хяналтын Албан Тушаалтан хянуулах хүсэлтийг хүлээн авсны дараа хараат бус хянан байцаагч томилно.
4. Хянан байцаагч сонсголын шийдвэрийг шударгаар хянана.
5. Хянан байцаагч дараах үүргүүдийг биелүүлнэ:
 - (a) Хэрэг хянан шалгах явцад талуудад өөрийн зардлаар өмгөөлөгчөөр төлөөлүүлэх эрхийг нь таниулан мэдэгдэх;
 - (b) Сонсголын тэмдэглэлийг шалгах;
 - (c) Хараат бус сонсголын үйл ажиллагаа нь эрх зүйн зохих журмын шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох;
 - (d) Хянан байцаагчийн шийдвэрээр талуудад бичгээр болон аман мэтгэлцэх, эсхүл аль алинаар нь мэтгэлцэх боломжийг олгох;
 - (e) шаардлагатай бол нэмэлт нотлох баримт шаардах; болон
 - (f) бичгээр шийдвэр гаргах.
6. Хянан байцаагч нь анхны шийдвэр хэт нэг талыг барьсан, алдаатай юм уу, хуульд харшилсан эсвэл нотлох баримтаар нотлогдоогүй зэрэг зөрчил илрээгүй бол анхан шатны шийдвэрийг хэвээр үлдээнэ.
7. Хянан байцаагч аль нэг талаас үргэлжлүүлэх хүсэлт гаргаагүй нөхцөлд томилогдсон өдрөөс хойш ажлын гуч (30) хоногийн дотор шийдвэрээ гаргах ёстой. Хүндэтгэн үзэх шалтгаантай бол хянан байцаагч хяналтыг үргэлжлүүлэхийг зөвшөөрч болно. Шийдвэрийн хуулбарыг бүх талуудад илгээх ёстой.
8. Захиргааны хэргийн сонсголын тэмдэглэлийг хянан байцаагч нь шийдвэр гарсны дараа Хэрэгжилт Хянах Албан Тушаалтанд илгээнэ.
9. Хэрэгжилт Хянах Албан Тушаалтан нь сонсголын бүх тэмдэглэлийг хариуцаж, эрх зүйн маргаан үүсэн нөхцөлд шүүхэд шилжүүлэх үүрэгтэй.

АРЛИНГТОНЫ УЛСЫН СУРГУУЛЬ
2110 WASHINGTON BLVD
ARLINGTON, VA 22204
УТАС. (703-228-8000)

SECTION 504-P ХАРААТ БУС СОНСГОЛ ХИЙХ ХҮСЭЛТ

“Section 504”-н дагуу хараат бус сонсгол явуулах хүсэлт гаргахын тулд энэ маягтыг сургуулийн дүүргийн “Section 504” Зохицуулагчид дараах хаягаар ирүүлнэ үү.

Arlington Public Schools
2110 Washington Blvd
Arlington, VA 22204

(Гаргацтай бичиж, гарын үсэг зурж, огноогоо бичнэ үү)

1. Хүүхдийн нэр: _____

Нас: _____ Төрсөн Огноо: _____

2. Хүүхдийн гэрийн хаяг: ⁵ _____

(Хот)

(Зип)

3. Сурагчийн суралцаж буй сургууль: _____

4. Эцэг эхийн нэр⁶ Сонсголын хүсэлт гаргаж буй: _____

Хаяг: _____

(Хот)

(Зип)

Утасны дугаар: Гэрийн () _____ Ажлын () _____

5. Хамаарах бол Эцэг эхийн төлөөлөгч (өмгөөлөгч г.м)

Нэр: _____

Хаяг: _____

(Хот)

(Зип)

Утасны дугаар: _____

⁵ Хэрэв гэр оронгүй хүүхэд, залуучууд байгаа нөхцөлд холбоо барих боломжтой мэдээллийг оруулна уу.

⁶ Эцэг эх гэдэгт хэрэв эцэг эхийн эрх нь тухайн сурагчид шилжсэн бол 18 нас хүрсэн сурагч, мөн мужийн хуулийн дагуу эцэг эх гэсэн тодорхойлолтод нийцэж буй бусад хүнийг ойлгоно.

6. Асуудлын мөн чанарын тодорхойлолт (үүссэн асуудлууд, ямар маргаан үүссэн г.м)

7. Асуудалтай холбоотой баримтууд (Асуудал юуны улмаас үүссэн г.м) _____

8. Мэдэгдэж буй хэмжээнд асуудлыг шийдвэрлэх санал болгож буй шийдэл.

(Шаардлагатай бол нэмэлт мэдээллийг шинэ хавсралтаар оруулж болно.)

ЖИЧ: Нөгөө тал зөвшөөрөөгүй нөхцөлд энэхүү мэдэгдэлд тусгаагүй шинэ асуудлыг сонсголын үед авч хэлэлцэхгүй.

ЗУУЧЛАЛ

Эвлэрүүлэн зуучлалыг талуудад үнэ төлбөргүй санал болгодог. Эвлэрүүлэн зуучлалыг харгалзан үзэхийг зөвлөх бөгөөд энэ нь таны хувьд ашигтай байж болох юм. Гэвч эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь маргааныг сайн дурын үндсэн дээр шийдвэрлэдэг тогтолцоо гэдгийг анхаарна уу. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхлэхээс өмнө хоёр тал өөрсдийн асуудлаа зуучлалаар шийдвэрлэхээр тохиролцсон байх ёстой. Эвлэрүүлэн зуучлах аливаа хүсэлт гаргах нь сонсголын ажилтныг томилох эсвэл сонсголыг товлох ажлыг хойшлуулах нөхцөл болохгүй. Эвлэрүүлэн зуучлалын саналыг хүлээн авах эсвэл татгалзах тухай шийдвэрээ доор бичнэ үү.

_____ Би эвлэрүүлэн зуучлал ашиглах хүсэлтэй байна.

_____ Би эвлэрүүлэн зуучлалаас татгалзаж байна.

Эцэг/ Эхийн гарын үсэг

Огноо

**ARLINGTON PUBLIC SCHOOLS
2110 WASHINGTON BLVD
ARLINGTON, VA 22204
УТАС. (703-228-8000**

SECTION 504 ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ

1973 оны Нөхөн Сэргээлтийн Тухай Хуулийн 504-р Хэсгийн (Section 504) дагуу Арлингтоны Улсын Сургууль таны хүүхдэд хамаарах дараах эрх зүйн хамгаалалтуудыг танд олгож байна.

1. Та хүүхдийг таньж илрүүлэх, үнэлэх болон хөтөлбөрт хуваарилахтай холбоотой санал болгож буй аливаа арга хэмжээний талаар мэдэгдэл хүлээн авах эрхтэй.
2. Та хүүхдийнхээ холбогдох бүх бүртгэлийг шалгах эрхтэй.
3. Та Америкийн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Тухай Хуулийн (ADA) 504-р хэсэг эсвэл II Зүйлийг зөрчсөн гэх үндэслэлээр сургуулийн дүүрэгт гомдол гаргах эрхтэй.
4. Та хүүхдийг таньж илрүүлэх, үнэлэх болон хөтөлбөрт хуваарилахтай холбоотой маргааныг өөрийн оролцоо, өмгөөлөгчийн оролцоотойгоор хараат бус сонсгол явуулах эрхтэй.
5. Хэрэв та шийдвэртэй санал нийлэхгүй байгаа бол хараат бус сонсголын ажилтны эцсийн шийдвэрт хяналт хийлгэх эрхтэй.

Арлингтоны Улсын Сургуулиудын Section 504 Хөтөлбөрийн Зохицуулагч Женнифер Ламбдин (Jennifer Lambdin). Тус албатай дараах утсаар холбогдож болно. (703) 228-8838. ADA-ийн 504-р Хэсэг эсвэл II Зүйлтэй холбоотой аливаа асуултыг Section 504 Хөтөлбөрийн Зохицуулагчтай холбогдож тодруулна уу. Та Арлингтон Улсын Сургуулийн Section 504 Хөтөлбөрийн Журмын Гарын авлагыг “Section 504” Хөтөлбөрийн Зохицуулагчтай дээрх утсаар холбогдож авах эсвэл Арлингтон Улсын Сургуулийн <https://www.apsva.us/> вэбсайтаас авна уу. Бүх гомдол болон хараат бус сонсгол, хяналт шалгалтын хүсэлтүүдийг бичгээр гаргаж, доорх хаягуудаар Арлингтоны Улсын Сургуулийн (АУС) “Section 504”-н Журмын гарын авлагад заасны дагуу “Section 504” Хөтөлбөрийн Зохицуулагч эсвэл “Section 504” Хөтөлбөрийн Хэрэгжилт Хянах Ажилтанд илгээх шаардлагатайг анхаарна уу:

Jennifer Lambdin
“Section 504” Зохицуулагч
Arlington Public Schools
2110 Washington Blvd
Arlington, VA 22204
Tel. (703) 228-8838
Email: jennifer.lambdin@apsva.us

Dr. Darrell Sampson
“Section 504” Хэрэгжилт Хянах Ажилтан
Сурагчийн Үйлчилгээний Алба Гүйцэтгэх Захирал
Arlington Public Schools
2110 Washington Blvd
Arlington, Va 22204
Tel. (703) 228-6061
Email: darrell.sampson@apsva.us

“Section 504” Хөтөлбөрийн сонсголын журам, гомдол гаргах журам, хяналтын журмын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийн дүүргийн “Section 504” Хөтөлбөрийн журмын гарын авлагад багтаасан болно.